



“ТӨВ ЦЭНГЭЛДЭХ ХҮРЭЭЛЭН”
ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ
КОМПАНИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Компанийн оноосон нэр (монголоор)

- а) Бүрэн нэр: “ТӨВ ЦЭНГЭЛДЭХ ХҮРЭЭЛЭН” ХХК /цаашид энэхүү дүрэмд “Компани” гэх/
б) Товчилсон нэр: “ТЦХ” ХХК



1.2.Компанийн оршин байгаа газар:

- Улсын нэр: Монгол улс
- Аймаг, нийслэлийн нэр: Улаанбаатар хот
- Сум, дүүргийн нэр: Хан-Уул дүүрэг
- Баг, хороо, хорооллын нэр: 15 дугаар хороо
- Гудамж, өргөн чөлөө, тойрог, талбайн нэр: Махатма Ганди гудамж
- Хашаа, байшин, хаалганы дугаар: 17011 Стадион оргил, 101/1
- Харилцах утасны дугаар: 99036767
- И-мэйл хаяг: ubstadium@gmail.com

1.3.Компанийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчийн мэдээлэл.

1.3.1.Төрийн тухайд:

- Хуулийн этгээдийн нэр, өөрийн нэр: Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
- Регистрийн дугаар: 9077111
- Хаяг: Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо
- Харилцах утасны дугаар: 324732

1.3.2.Хуулийн этгээдийн тухайд: /толгой компани байхгүй тохиолдолд бөглөхгүй/

- Хуулийн этгээдийн нэр, хэлбэр: Хязгаарлагдмал хариуцлагатай компани
- Улсын бүртгэлийн дугаар: 9011096140
- Регистрийн дугаар: 2027496

1.4.Компани нь бие даасан тайлан тэнцэлтэй, харилцах данстай, өөрийн нэрийн өмнөөс эрх эдлэн, үүрэг, хариуцлага хүлээх, нэг хувьцаа эзэмшигчтэй, хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрээр ажиллана.

1.5.Компани нь үйл ажиллагаагаа дараах чиглэлээр явуулна.

1.5.1. Төрийн ёслол, Улсын баяр наадам, урлаг соёл спортын арга хэмжээ зохион байгуулах

1.5.2. Өөрийн байр, талбайг түрээслэх үйлчилгээ

1.5.3. Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа

1.6. Компани нь тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагааг хуульд заасны дагуу холбогдох эрх бүхий байгууллагаас зөвшөөрлийг бичгээр авч, энэхүү дүрэмдээ өөрчлөлт оруулан бүртгэх байгууллагад бүртгүүлнэ.

1.7.Компанийн үйл ажиллагаа эрхлэх хугацаа: Хугацаагүй, Хугацаа жил.
/доогуур нь зурах буюу хугацааг бичих/

1.8.Компани нь Монгол Улсад болон гадаад улсад өөрийн салбар, төлөөлөгчийн газартай байж болно. Компанийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу салбар,

төлөөлөгчийн газраа байгуулан, бүртгэх байгууллагад бүртгүүлж, үйл ажиллагаагаа явуулна.

1.9.Компани нь үүсгэн байгуулах баримт бичигт болон улсын бүртгэлийн жагсаалтад агуулагдаж байгаа бусад мэдээлэлд оруулсан өөрчлөлтүүдээ хуульд заасан хугацаанд бүртгэх байгууллагад бүртгүүлнэ.

Хоёр. Компанийн эрх

2.1.Компанийн иргэний эрх зүйн чадвар нь улсын бүртгэлд бүртгүүлснээр үүснэ.

2.2.Компани нь өөрийн бэлэгдэл (эмблем), албан бичгийн хэвлэмэл хуудас, өөрийн нэр бүхий тэмдэг хэрэглэнэ.

2.3.Компани нь Компанийн тухай хуулийн 6.1-6.8 дахь хэсэгт заасны дагуу хараат болон охин компани байгуулж болох бөгөөд үүнийгээ бүртгэх байгууллагад бүртгүүлнэ.

2.4.Компани нь өөрийн үйл ажиллагаагаа бие даасан байдлаар, эсхүл бусад хуулийн этгээдтэй хамтран Монгол Улсын хуулийн хүрээнд эрхлэн явуулна.

2.5.Компани нь үндсэн ба туслах үйл ажиллагаагаа хэвийн явуулах зорилгоор мэргэжил, ур чадвар, дадлага туршлагатай хүмүүсийг хөдөлмөрийн гэрээгээр авч ажиллуулах, тэдгээрийн ажиллах нөхцөл, цалин хөлс, урамшууллын хэмжээг тогтооно.

Гурав. Компанийн үүрэг

3.1.Компани нь энэхүү дүрмийн 1.5, 1.6-д заасан үйл ажиллагааг Монгол Улсын хуульд заасны дагуу эрхлэнэ.

3.2.Компани нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Аудитын тухай хууль болон Компанийн тухай хуулийн 96 дугаар зүйлд заасны дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөн, санхүүгийн тайлан гаргана.

3.3.Компани нь Монгол Улсын албан татварын хуулийн дагуу орлого, татвараа өөрөө тодорхойлж, албан татвараа сайн дураар төлнө.

3.4.Компани нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шаардлагатай мэдээ, мэдээллийг тухай бүр эрх бүхий байгууллагуудад гаргаж өгнө.

3.5.Компани нь хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсадын өмнө хуулиар өгөгдсөн үүргүүдийг биелүүлнэ.

3.6.Компанийн тухай хуулийн 84.1, 84.2 дахь хэсэгт заасны дагуу компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно.

3.7.Компани нь Компанийн тухай хуулийн 97 дугаар зүйлд заасан баримт бичгийг хадгалах, байнга хадгалах, хувьцаа эзэмшигчийн шаардлагаар танилцуулах, тэдгээрийг архивт шилжүүлнэ.

Дөрөв. Компанийн хариуцлага

4.1.Компани нь Компанийн тухай хуулийн 9.1 дэх хэсэгт заасан хариуцлага хүлээнэ.

4.2.Компани нь хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсадын эрхийг зөрчсөн тохиолдолд холбогдох хуульд заасан хариуцлага хүлээнэ.

4.3.Компани нь улсын бүртгэлд бүртгүүлэхээсээ өмнө иргэний эрх зүйн харилцаанд бие даан оролцохыг хориглоно. Энэхүү заалтыг зөрчсөний улмаас бусдад гэм хор учруулсан бол буруутай этгээд гэм хорыг арилгана.

4.4.Компанийн эрх бүхий албан тушаалтан нь Компанийн тухай хуулийн 84, 85 дугаар зүйлд заасан хариуцлагыг хүлээнэ.

4.5.Компани нь Монгол Улсын хуульд заасан бусад хариуцлагыг хүлээнэ.

Тав. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө болон өөрийн хөрөнгө

5.1.Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг Компанийн тухай хуулийн 30.1 дэх хэсэгт зааснаар тодорхойлно.

5.2.Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь 201,046,000.00 /Хоёр зуун нэгэн сая дөчин зургаан мянган/ төгрөг ба нэг бүр нь 2,010,460 /хоёр сая арван мянга дөрвөн зуун жар/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 100 /зуу/ ширхэг энгийн хувьцаа байна.

5.3.Компанийн өөрийн хөрөнгийн хэмжээг Компанийн тухай хуулийн 30.2 дахь хэсэгт зааснаар тодорхойлно.

5.4.Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь компанийн өөрийн хөрөнгийн хэмжээнээс илүүгүй байна.

5.5.Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөхдөө Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасныг баримтлана.

5.6.Компанийн хувьцаа, компанийн зарласан болон гаргасан хувьцаатай холбоотой асуудлыг Компанийн тухай хуулийн 32, 33 дугаар зүйлд зааснаар шийдвэрлэнэ.

Зургаа. Компанийн удирдлага

6.1.Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хувьцаа эзэмшигч өөрөө хэрэгжүүлнэ.

6.2.Компанийн гүйцэтгэх захирлыг хувьцаа эзэмшигчийн шийдвэрээр сонгож, өөрчилнө. Гүйцэтгэх захиралтай хувьцаа эзэмшигч гэрээ байгуулна.

6.3.Компанийн хувьцаа эзэмшигч нь компаниа өөрчлөн байгуулах асуудлыг шийдвэрлэнэ.

6.4.Компанийг өөрчлөн байгуулсантай холбогдуулан хувьцаа эзэмшигч Компанийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасан эрхийг эдлэнэ.

Долоо. Хувьцаа эзэмшигчдийн хурал

7.1. Компанийн үүсгэн байгуулагч нь Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал (цаашид НИТХ гэнэ) байна.

7.2. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь Компанийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлнэ.

7.3. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь бүрэн эрхийнхээ хүрээнд энэхүү дүрэм болон хууль, тогтоомжоор компанийн үйл ажиллагаатай холбоотой аливаа асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх эрхтэй бөгөөд компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийн хүрээнд дараах асуудлыг өөрийн үйл ажиллагаа явуулах журмын дагуу хэлэлцэн шийдвэрлэнэ.

7.3.1. компани нийлэх, нэгдэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх хэлбэрээр компанийг өөрчлөн байгуулах;

7.3.2. компанийн хэлбэрийг өөрчлөх;

7.3.3. охин болон хараат компани байгуулах, татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;

7.3.4. компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;

7.3.5. компанийн зарласан хувьцааны төрөл болон хэмжээнд багтаан хувьцаа гаргах асуудлыг шийдвэрлэх;

7.3.6. компанийн гаргасан давуу эрхийн хувьцаанаас бусад үнэт цаасыг худалдах, худалдан авах, эргүүлэн авах шийдвэр гаргах;

7.3.7. компанийн төлөөлөн удирдах зөвлөлийг томилох, чөлөөлөх;

7.3.8. төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох;


7.3.9. хэрэв Төлөөлөн удирдах зөвлөл их хэмжээний болон сонирхлын зөрчил бүхий хэлцэл хийх асуудлыг шийдвэрлэж чадаагүй бол тэдгээрийн талаар шийдвэр гаргах;

7.3.10. компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал.

7.4. Шаардлагатай гэж үзвэл Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийн хүрээний асуудлыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хэдийд ч тавьж шийдвэрлүүлж болно.

7.5. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хувьцаа эзэмшигчийн хувьд компанийн хууль ёсны ашиг сонирхолыг хүндэтгэн, бие даасан, үр ашигтай үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлж, компанийн хөрөнгийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн аливаа бодлого, шийдвэрээр тогтвортой дэмжиж ажиллана.

Найм. Төлөөлөн удирдах зөвлөл



8.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл байна.

8.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь 9 (ес) гишүүнтэй байх бөгөөд 1/3 нь НИТХ-с, 1/3 нь төрийн мэргэжлийн албан хаагч, 1/3, нь хараат бус гишүүн байх ба тэдгээрийг хуульд заасны дагуу нэр дэвшүүлж, томилж, чөлөөлнө.

8.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаа явуулах үндсэн хэлбэр нь түүний хурал байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг хагас жилд нэг удаа хуралдуулах бөгөөд шаардлага гэж үзвэл нэмэлт хурлыг хэдийд ч хийж болно.

8.4. Төлөөлөн удирдах зөвлөл нь өөрийн үйл ажиллагааг байнгын, тогтмол, мэргэшсэн явуулах зорилгоор тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороог байгуулж болно.

8.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ:

8.5.1. компанийн зохион байгуулалтын бүтэц, орон тоог батлах;

8.5.2. компанийн төсөв, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах;

8.5.3. бүтээгдэхүүний борлуулалт, маркетингийн төлөвлөгөөг батлах;

8.5.4. компанийн хөрөнгө оруулалтын талаар баримтлах бодлого, чиглэлийг тодорхойлох;

8.5.5. компанийн стратегийн зорилтуудыг тодорхойлж, урт хугацааны болон дунд хугацааны бизнес төлөвлөгөөг батлах;

8.5.6. компанийн үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын зардлын дээд хязгаарыг тогтоох;

8.5.7. компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болон гүйцэтгэх захирлыг томилох, чөлөөлөх;

8.5.8. компанийн гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээний нөхцөл, түүнд олгох цалин, шагнал урамшуулал, өмч хөрөнгийг захиран зарцуулах эрх, хариуцлагын хэмжээг тогтоох, гэрээ байгуулах

8.5.9. компанийн салбар, төлөөлөгчийн газар байгуулах, нээж ажиллуулах, татан буулгах, удирдлагыг томилох, чөлөөлөх асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх;

8.5.10. компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргах;

8.5.11. эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох;

8.5.12. компанийн тайлан тэнцэлд хийсэн хөндлөнгийн аудитын дүгнэлтийг хэлэлцэж шийдвэр гаргах;

8.5.13. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмыг болон төлөөлөн удирдах зөвлөлийн хороодын дүрэм, журмыг батлах;

8.5.14. компанийн шинээр худалдаж авах болон акталж, данснаас хасах эд хөрөнгийн асуудлыг хэлэлцэж, шийдвэрлэх;

- 8.5.15. худалдах, шилжүүлэх үндсэн хөрөнгийн асуудлыг хэлэлцэж, дүгнэлт гаргах;
- 8.5.16. компанид орсон орлогыг хуваарилах, хөрөнгө оруулалтын төрөл, хэмжээг тогтоох, батлах;
- 8.5.17. компанийн мэдэлд үлдээсэн эрсдэлийн хуримтлалын хэмжээг тодорхойлох, зарцуулах журмыг батлах;
- 8.5.18. хуульд өөрөөр заагаагүй бол компанийн зүгээс Нийслэлийн төсөвт оруулах орлого буюу ногдол ашгийн хэмжээг тодорхойлох;
- 8.5.19. их хэмжээний болон сонирхлын зөрчил бүхий гэрээ хэлцлийн үнэ болон хийх эсэх талаар шийдвэр гаргах;
- 8.6. Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг гишүүдийн дотроос томилж, чөлөөлнө.
- 8.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нь Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулж, түүний хурлыг хуралдуулах, хурал даргалах, хурлын тэмдэглэлийг хөтлүүлэх, түүнд хяналт тавих үүргийг хүлээнэ.
- 8.8. Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг түр эзгүйд түүний үүргийг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаас үүрэг болгосны дагуу аль нэг гишүүн гүйцэтгэнэ.
- 8.9. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нь Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аль нэг хорооны даргын ажлыг хавсран гүйцэтгэхгүй.
- 8.10. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйлд заасан журмын дагуу хуралдуулна.
- 8.11. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал гишүүдийнх нь дийлэнх олонхи гуравны хоёр (2/3) оролцсоноор хүчин төгөлдөр болж, хуралд оролцсон саналын эрхтэй гишүүдийн дийлэнх олонхи гуравны хоёр (2/3)-ын саналаар хурлын шийдвэр хүчин төгөлдөр болно.
- 8.12. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн зөвхөн өөрийн биеэр хуралд оролцож эрх хэмжээгээ хэрэгжүүлэх бөгөөд өөр этгээдээр төлөөлүүлж хуралд оролцохыг хориглоно.
- 8.13. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг хуралдуулах, хурал хүчинтэй байх, гишүүдийн хуралд оролцох, асуудал хэлэлцэх, хурлын дэгийг тогтоох, төлөөлөн удирдах зөвлөлийн даргын эрх, үүрэг болон бусад холбогдох асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журамд тусгана.
- 8.14. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын санал болгосны дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас томилно. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын эрх, үүргийг Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журамд тусгана.
- 8.15. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд нь цалин, урамшуулалтай байх бөгөөд цалин, урамшууллын хэмжээ нь НИТХ болон холбогдох эрх бүхий байгууллагаас тусгайлан тогтоосон жишиг хэмжээтэй нийцэхүйц байна.
- 8.16. Төлөөлөн удирдах зөвлөл нь жилд 1 (нэг)-ээс доошгүй удаа хувьцаа эзэмшигчдийн хуралд ажлаа тайлагнана.

Ес. Компанийн гүйцэтгэх удирдлага

- 9.1. Компанийн гүйцэтгэх удирдлагыг Гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ.
- 9.2. Гүйцэтгэх захирлыг Хувьцаа эзэмшигч томилж, чөлөөлнө.
- 9.3. Гүйцэтгэх захирал нь компанийн дүрэм болон Төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, хэлцэл хийх, гэрээ байгуулах, компанийн эрх

ашгийн төлөө түүнийг Монгол Улс болон хилийн чанадад төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна.

9.4. Гүйцэтгэх захирал нь гүйцэтгэх удирдлагын гишүүн тус бүртэй гэрээ байгуулах бөгөөд гэрээнд тэдний эрх, үүрэг, цалин, шагнал урамшуулал, хангамж, өмч хөрөнгийг захиран зарцуулах эрх, хариуцлагын хэмжээ болон бусад асуудлыг тусгана.

9.5. Гэрээний биелэлтийг дүгнэх, урамшуулал олгох журмыг Төлөөлөн удирдах зөвлөлөөс батална.

9.6. Гүйцэтгэх захирал нь албан үүргээ хэрэгжүүлэх явцдаа энэхүү дүрэм, гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчиж, компанийн нэр хүнд, эдийн засгийн байдалд ноцтой хохирол учруулсан болох нь тогтоогдвол Төлөөлөн удирдах зөвлөл нь бүрэн эрхийг зогсоох тухай шийдвэрийг гаргана.

9.7. Гүйцэтгэх удирдлагын гишүүдийн албан үүргээ хэрэгжүүлэх явцдаа энэхүү дүрэм, гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчиж, компанийн нэр хүнд, эдийн засгийн байдалд ноцтой хохирол учруулсан болох нь тогтоогдвол Гүйцэтгэх захирал нь бүрэн эрхийг зогсоох шийдвэрийг гаргаж шийдвэрлэнэ.

9.8. Гүйцэтгэх захирал нь дараах шалгуурыг хангасан байна:

9.8.1. менежментийн өндөр ур чадвартай, 10 (арав)-аас доошгүй жил удирдах ажил гүйцэтгэж байсан дадлага туршлагатай, санхүү эдийн засаг, хүнд үйлдвэрийн салбарын дээд боловсролтой байх;

9.8.2. зээл буюу батлан даалтын гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өргүй байх;

9.8.3. ял шийтгэлгүй байх;

9.8.4. ёс зүйн болон бизнесийн нэр хүнд нь компанийг удирдахад харшлахгүй байх.

9.9. Гүйцэтгэх захирал нь дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

9.9.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн өмнө компанийн үйл ажиллагааг бүрэн хариуцаж, жилд 2 (хоёр)-оос доошгүй удаа ажлын үр дүнгээ тайлагнан дүгнүүлэх;

9.9.2. компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан тэнцлийг цаг тухайд нь гаргаж, холбогдох этгээдүүдэд тайлагнаж мэдээлэх үүрэгтэй бөгөөд түүний үнэн зөвийг хариуцах;

9.9.3. компанийн дотоод журам, заавар, аргачлал, ажил үүргийн хуваарь баталж мөрдүүлэх, компанийн ажиллагсдад сахилгын шийтгэл ногдуулах;

9.9.4. хууль тогтоомжийн хэрэгжилт, санхүү, аж ахуйн үйл ажиллагаа, хөрөнгө зарцуулалт, ашиглалт, компанийн хөдөлмөрийн дотоод журамд хяналт тавих дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх;

9.9.6. компанийн үйл ажиллагааны бизнес төлөвлөгөө, жилийн төсөв болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийг боловсруулж, төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оруулан шийдвэрлүүлэх, түүний хэрэгжилтийг зохион байгуулах;

9.9.7. компанийн бодлого, түүний хэрэгжилттэй холбогдсон асуудлаар НИТХ, Засаг дарга, холбогдох бусад байгууллагатай шууд харилцаж, байр сууриа илэрхийлэх;

9.9.8. Төлөөлөн удирдах зөвлөлийн даргатай байгуулсан гэрээний хүрээнд хамаарах асуудлаар компанийг төлөөлөх итгэмжлэл олгох;

9.9.9. компанийн нууцад хамаарах мэдээлэл, материалын жагсаалт болон нууц хамгаалах журмыг хууль тогтоомжид нийцүүлэн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар батлуулан мөрдүүлэх;

9.9.10. энэхүү дүрэм болон холбогдох хууль тогтоомж, норм норматив, компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр, Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр, үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулах;

9.9.11. гэрээгээр хүлээсэн үүргийг биелүүлэх, компанийн санхүү, төлбөрийн чадвар, нэр хүндийг дээшлүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа явуулах;

9.9.12. үүрэг гүйцэтгэх явцад олж авсан мэдээллийг хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн ашиглахгүй байх;



9.9.13. компанийн бүтэц, зохион байгуулалтын талаар санал боловсруулж төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулах, баталсан орон тоо, зохион байгуулалтын бүтцийн хүрээнд ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг батлах, ажилтныг ажилд томилох, тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах, ажлаас чөлөөлөх;

9.9.14. компанийн шинээр худалдан авах болон акталж устгах, худалдах, шилжүүлэх үндсэн хөрөнгийн асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оруулах;

9.9.15. компанийн үйл ажиллагаатай холбогдох асуудлаар тушаал гаргаж, биелэлтийг хангуулах;

9.9.16. мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, давтан сургах ажлыг хариуцан зохион байгуулах;

9.9.17. компанийн бэлгэдэл, тэмдгийн загварыг батлах;

9.9.20. хууль болон энэхүү дүрэм, гэрээнд заасан бусад эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

9.10. Гүйцэтгэх захирал нь эрх, үүргээ түр хугацаанд компанийн бусад эрх бүхий албан тушаалтанд шилжүүлж болно. Ийнхүү эрхээ итгэмжлэн шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

9.11. Компанийн гүйцэтгэх удирдлага нь энэхүү дүрэмд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой орон тооны болон орон тооны бус мэргэжлийн зөвлөх буюу зөвлөх багийг авч ажиллуулах асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцүүлж, шийдвэрлүүлж болно.

9.1. Компанийн тухай хуулийн 84.1-д заасны дагуу дараах этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно:

9.1.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн;

9.1.2. Гүйцэтгэх захирал;

9.1.3. Захиргааны асуудал эрхэлсэн нэгжийн дарга

9.1.4. Үйлдвэрлэл технологийн асуудал эрхэлсэн нэгжийн дарга

9.1.5. Санхүүгийн асуудал хариуцсан нэгжийн дарга;

9.1.6. Ерөнхий нягтлан бодогч;

9.1.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга;

9.1.8. Шийдвэр гаргахад болон гэрээ, хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцож буй бусад этгээд.

9.2. Эрх бүхий албан тушаалтан нь Компанийн тухай хуульд заасны дагуу өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн талаархи болон бусад мэдээллийг хууль тогтоомжийн дагуу холбогдох байгууллага, эрх бүхий албан тушаалтанд өгч энэхүү дүрэм, дотоод журамд заасан үүргийг биелүүлж, компанийн ашиг сонирхлын төлөө үнэнч шударгаар ажиллана.

9.3. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь дараах үүрэгтэй байна:

9.3.1. хууль болон компанийн дүрэм, журамд заасан бүрэн эрхийн хүрээнд ажиллаж, эрх мэдлээ хэрэгжүүлэх;

9.3.2. үйл ажиллагаандаа компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримталж, Компанийн тухай хууль болон энэхүү дүрмээр тогтоосон үүргээ чанд биелүүлэх;

9.3.3. үйл ажиллагаагаа хараат бус бие даасан байдлаар явуулж, хувьцаа эзэмшигч, харилцагч болон бусад оролцогч талуудын эрх ашгийг тэргүүн зэрэгт тавьж ашиг сонирхлын зөрчил гаргахгүй байх;

9.3.4. шууд болон шууд бус байдлаар эсхүл гуравдагч талын нэрийн өмнөөс компанид нөлөөлж болох аливаа хэлцэл, материаллаг сонирхолтой асуудлын талаар төлөөлөн удирдах зөвлөлд мэдэгдэх;

9.3.5. компанийн эрх ашигт нийцүүлэн үндэслэлтэй шийдвэр гаргах;

9.3.6. шийдвэр гаргахдаа сонирхлын зөрчлөөс зайлсхийж сонирхлын зөрчил үүсэхээр бол энэ тухайгаа тухай бүр Төлөөлөн удирдах зөвлөл, аудитор мэдэгдэх;

9.3.7. өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хөндлөнгийн этгээдээс бэлэг, урамшуулал авахгүй байх;

9.3.8. компанийн эрх бүхий албан тушаалтан нь тухайн албан тушаалд томилогдсоноос хойш 10 (арав) хоногийн дотор Компанийн тухай хуулийн 99 дүгээр зүйлд заасан өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг гаргаж, Төлөөлөн



удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргад өгөх бөгөөд уг жагсаалтад өөрчлөлт орох бүрт 10 (арав) хоногийн дотор компанид мэдэгдэнэ;
9.3.9. компанийн нууцад хамаарах мэдээллийг бусдад задруулах, хувийн сонирхлын зорилгоор ашиглахгүй байх.

9.4. Компанитай байгуулсан гэрээгээр илүү урт хугацаа тогтоогоогүй бол компанийн эрх бүхий албан тушаалтан албан тушаалаасаа өөрчлөгдсөнөөс хойш 3 (гурав) жилийн туршид энэ дүрмийн 11.3.9-д заасан үүргийг хүлээнэ.

Арав. Компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд тавих хяналт

10.1. Компанийн хувьцаа эзэмшигч Компанийн тухай хуулийн 94.1 дэх хэсэгт зааснаар гэрээний үндсэн дээр аудитын байгууллагыг томилон ажиллуулж болно.

10.2. Компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийх аудитын байгууллагын шалгалт нь ээлжит ба ээлжит бус байна.

10.3. Компанийн жилийн санхүүгийн тайлан баталгаажуулахын тулд хийсэн аудитын байгууллагын шалгалт нь ээлжит байна.

10.4. Аудитын байгууллагын шалгалтын хөлсийг Компанийн тухай хуулийн 94.8 дахь хэсэгт заасны дагуу компани болон хувьцаа эзэмшигч хариуцан төлнө.

10.5. Компани нь санхүүгийн тайлангаа эрх бүхий этгээдэд танилцуулна

10.6. Компанийн санхүүгийн жил 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхэлж, 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болно.

10.7. Компани нь компанийн санхүүгийн тайланд Компанийн тухай хуулийн 96.1 дэх хэсэгт заасан зүйлийг тусгана.

10.8. Компани нь Компанийн тухай хуулийн 97 дугаар зүйлд заасан баримт бичгийг хадгалах, байнга хадгалах, эрх бүхий этгээдийн шаардлагаар танилцуулах, хуульд заасан хугацаа дууссаны дараа архивт шилжүүлнэ.

Арван нэг. Компанийг өөрчлөн байгуулах

11.1. Компанийн хувьцаа эзэмшигч нь компанийг өөрчлөн байгуулахдаа Компанийн тухай хуулийн 18-23 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.

Арван хоёр. Компанийг татан буулгах

12.1. Компанийг Компанийн тухай хуулийн 26 дугаар зүйлд заасан үндэслэлээр татан буулгана.

12.2. Компанийг татан буулгах шийдвэр гаргасан эрх бүхий этгээд татан буулгах комиссыг томилно.

12.3. Компанийг татан буулгах шийдвэр гаргасан эрх бүхий этгээд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 24.1 дэх хэсэгт заасан хугацаанд бүртгэх байгууллагад бичгээр мэдэгдэж, холбогдох баримт бичгийг хавсаргасан байна.

12.4. Татан буулгах комисс Иргэний хуулийн 32.2-32.10 дахь хэсэг, Компанийн тухай хуулийн 26, 27, 28 дугаар зүйлд заасны дагуу компанийг татан буулгах ажлыг эрхлэн гүйцэтгэнэ.

12.5. Компани татан буугдсаныг улсын бүртгэлд бүртгүүлэхдээ Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 25 дугаар зүйлд заасан баримт бичгийг бүрдүүлж бүртгэх байгууллагад ирүүлнэ.

Арван гурав. Бусад зүйл

13.1.Энэхүү дүрмийг монгол хэлээр 3 хувь үйлдэж, нэг хувийг бүртгэх байгууллагад, хоёр хувийг компанийг улсын бүртгэлд бүртгүүлэх эрх бүхий этгээдэд өгнө.

13.2.Компанийн дүрмийг улсын бүртгэлд бүртгүүлснээр хүчин төгөлдөр болсонд тооцогдоно.

